

“Монгол-Хятадын мөнгө санхүүгийн хамтын ажиллагаа” анхдугаар форум дээр БНХАУ-ын ЭСЯ-ны худалдааны зөвлөх Сун Вэйрэний хэлсэн үг

Хүндэт зочид оо! Хадагтай ноёд оо:

Миний бие Бүрэн эрхт элчин сайд Ван Сяолунгийн хүсэлт ёсоор БНХАУ-аас Монгол улсад суугаа элчин сайдын яамны нэрийн өмнөөс “Монгол-Хятадын мөнгө санхүүгийн хамтын ажиллагаа” анхдугаар форумын үйл ажиллагаанд халуун баяр хүргэж байгаагаа илэрхийлье.

Бид бүхний мэдэж байгаагаар саяхан Хятад улсын дарга Си Зиньпин Монгол улсад айлчлан хоёр улсын харилцааг стратегийн иж бүрэн түншлэлийн шинэ түвшинд хүргэсэн билээ. Энэ үндсэн дээр Хятадын тал харилцан ашигтай байх зарчмыг баримтлан Монголын талтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж хамтаар хөгжих, хөгжил дэвшлийн үр ашгийг хамтдаа хүртэн байж хоёр орны ард иргэдэд аз жаргал авчирах нь дамжиггүй.

Өнгөрсөн хугацааны турш хоёр улсын засгийн газар хооронд эрдэс баялаг, дэд бүтэц, банк санхүүгийн салбарын хамтын ажиллагааг гурвалсан цогц байдлаар ахиулах зарчмыг баримталсаар ирсэн. Бодит байдал дээр уул уурхай, дэд бүтцийн салбарын хамтын ажиллагаа өргөжин нилээд амжилтанд хүрсэн боловч банк санхүүгийн салбарын хамтын ажиллагаа нилээд хязгаарлагдмал байж ирсэн. Энэ бодит нөхцөл байдлаас гадна хоёр орны банк санхүүгийн салбарын судалгаа, харилцан ойлголцол дутмаг байгаагаар нилээд холбоотой.

Өнөөгийн эдийн засаг бол зах зээлийн эдийн засаг юм. Энэ зах зээлийн эдийн засгийн мөн чанараас авч үзвэл хөгжсөн, найдвартай

мөнгөн дэвсгэртийн эдийн засаг буюу банк санхүүгийн эдийн засаг гэж хэлж болно. Эрүүл тогтвортой банк санхүүгийн үйл ажиллагаа нь нийгмийн баялгийн зохистой хуваарилалтыг биелүүлж улс хоорондын эдийн засгийн хөгжил дэвшлийг авчирдаг.

Нөгөө талаас авч үзвэл банк санхүү нь макро эдийн засгийг зохицуулах хөшүүрэг болж өгдөг, банк санхүүгийн салбар нь бүхий л салбарыг холбодог, мянга мянган аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг нарийн тусгаж чаддаг, зээлийн хүү, ханш, зээл, тооцоо зэрэг нь аж ахуйн нэгжүүдэд шууд нөлөөлж чаддаг. Энэ утгаас нь авч үзвэл банк санхүүгийн эрүүл тогтолцоо улс орны эдийн засгийн эрүүл тогтвортой хөгжлийн суурь юм. Иймээс Хятад, Монгол хоёр орны засгийн газар хамтарсан мэдэгдэл гаргаж банк санхүүгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, мөнгөн дэвсгэрт харилцан солилцох своп хэлцэлийн дүнг 10 тэрбум байснаас 15 тэрбум болгон нэмэгдүүлж, арилжааны зээл олголт болон төслийн санхүүжилт, мөнгөн дэвсгэртийн тооцоо зэргийг дэмжих чиглэлээр хамтын ажиллагаа хөгжүүлсээр ирлээ.

Хятадын тал Хятадын банк санхүүгийн байгууллага Монголд салбараа нээн үйл ажиллагаа явуулахыг Монголын тал дэмжиж ажиллана гэдэгт найдаж байна. Энэ нь Монголын эдийн засгийн хөгжил төдийгүй хоёр орны банк санхүүгийн хамтын ажиллагаанд олон арвин боломж ба орон зайг авчирах юм.

Энэ форумар дамжин хоёр орны банк санхүүгийн салбарын мэргэжилтэнүүд харилцан ойлголцоолоо зузаатгаж, хоёр улсын засгийн газар хоорондын банк санхүүгийн салбарын хамтын ажиллагаанд чиглэсэн хэрэгжиж болохуйц хөтөлбөрийг дэвшүүлэн Хятад-Монгол хоёр орны худалдаа эдийн засгийн бүх талын хамтын ажиллагааг ахиулж, Монголын эдийн засгийг эрчимжүүлэхэд хувь нэмэр үзүүлж чадна гэдэгт би итгэж байна.

Форумын үйл ажиллагаанд дахин амжилт хүсье!

Баярлалаа!